



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2022

11 САР

СТАТИСТИКИЙН
ТАНИЛЦУУЛГА



www.ubstat.mn



www.facebook.com/StatisticUlaanbaatar



www.1212.mn

АГУУЛГА

	ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2018-2022 ОН	1
	ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР	2
	ЭРҮҮЛ МЭНД	4
	ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ	9
	ГЭМТ ХЭРЭГ	15
	ТӨСӨВ	19
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	23
	АЖ ҮЙЛДВЭР	34
	ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙ	40

ХҮСНЭГТ 1. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 11 сар

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022
Шинээр төрсөн хүүхэд		хүн	↑ 37 231 ↑6.6	↑ 37 686 ↑1.2	↓ 36 554 ↓3.0	↓ 33 737 ↓7.7	↓ 32 010 ↓5.1
Халдварт өвчнөөр өвчлөгчид		хүн	↓ 20 620 ↓17.1	↑ 21 950 ↑6.5	↓ 16 218 ↓26.1	↑ 245 211 ↑15.1**	↓ 182 966 ↓26.1
Бүртгэгдсэн гэмт хэрэг		тоо	↑ 23 855 ↑22.0	↓ 19 222 ↓19.4	↓ 14 117 ↓26.6	↑ 14 920 ↑5.7	↑ 22 471 ↑52.4
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		хувь	↑ 2.2 ↑2.3	↓ 0.1 ↓2.1	↑ 0.7 ↑0.6	↑ 1.5 ↑2.1	↓ 0.9 ↓0.6
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	төгрөг	↑ 2 627 ↑7.5	↑ 2 715 ↑3.3	↑ 2 850 ↑5.0	↓ 2 849 ↓0.1	↑ 3 406 ↑19.5
	Юань (БНХАУ)	төгрөг	↑ 378 ↑2.2	↑ 386 ↑2.1	↑ 433 ↑12.2	↑ 447 ↑3.2	↑ 474 ↑6.0
	Рубль (ОХУ)	төгрөг	↓ 39 ↓7.1	↑ 42 ↑7.7	↓ 37 ↓11.9	↑ 38 ↑2.7	↑ 55 ↑44.7
Нийслэлийн төсвийн орлого		тэрбум төгрөг	↑ 754.9 ↑23.0	↑ 815.3 ↑9.6	↓ 733.5 ↓10.0	↑ 1 016.6 ↑38.6	↑ 1 379.1 ↑36.0
Нийслэлийн төсвийн зарлага		тэрбум төгрөг	↑ 1 125.1 ↑31.7	↑ 1 136.9 ↑1.0	↓ 1 092.3 ↓3.9	↓ 1 084.0 ↓0.7	↑ 1 486.3 ↑37.1
Агаарын дундаж температур		°C	-8.8	-10.0	-16.1	-8.0	-10.6

Тайлбар: Өмнөх онтой харьцуулсан


 Эерэг хандлага, өөрчлөлт

 Сөрөг хандлага, өөрчлөлт

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2021 I-XI					2022 I-XI				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	323	Баянгол	7 961	Налайх	57	331	Баянгол	8 109	Налайх	57
			Чингэлтэй	1 714	Багануур	48		Чингэлтэй	1 703	Багануур	48
			Сүхбаатар	700	Багахангай	33		Сүхбаатар	700	Багахангай	33
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	11	Налайх	17	Баянзүрх	9	12	Сонгинохайрхан	13	Багануур	9
			Сонгинохайрхан	11	Хан-Уул	7		Сүхбаатар	11	Хан-Уул	8
			Баянгол	10	Багахангай	-		Баянгол	11	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	1 652	Хан-Уул	1 316	Багануур	824	1 204	Багахангай	2 491	Сүхбаатар	917
			Баянзүрх	1 273	Сонгинохайрхан	782		Налайх	2 066	Чингэлтэй	729
			Баянгол	1 181	Багахангай	619		Хан-Уул	1 242	Сонгинохайрхан	630
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	94	Чингэлтэй	86	Налайх	16	93	Баянзүрх	149	Сонгинохайрхан	102
			Хан-Уул	56	Багануур	15		Хан-Уул	118	Налайх	68
			Сүхбаатар	53	Багахангай	9		Чингэлтэй	109	Багахангай	23
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	153	Сүхбаатар	212	Сонгинохайрхан	101	233	Сүхбаатар	367	Налайх	123
			Чингэлтэй	166	Налайх	83		Баянгол	271	Багануур	99
			Баянгол	161	Багахангай	63		Чингэлтэй	261	Багахангай	74

Тайлбар: * промилль

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).


II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрбум	=10 ⁹
их наяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД (2022 оны эхний 11 сард)

ᠡᠷᠦᠭᠦᠯᠡ ᠮᠡᠨᠳᠡ

Амаржсан эх



2021 I-XI 33 455

2022 I-XI 31 721

5.2%



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2021 I-XI 245 211

2022 I-XI 182 966

25.4%



Нялхсын эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2021 I-XI 11.0

2022 I-XI 12.4

5 хүртэлх насны хүүхдийн
эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2021 I-XI 13.0

2022 I-XI 14.7

ЭРҮҮЛ МЭНД


Нийслэлийн хэмжээнд 2022 оны эхний 11 сард 31721 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 1734 (5.2%) төрөлтөөр буурсан байна. Нийт төрөлтийн 1319¹(4.2%) нь НЭМГ-ын харьяа эмнэлэгт, 30402 (95.8%) нь нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ЭМЯ-ны харьяа улс болон хувийн хэвшлийн эмнэлэгт амаржсан байна. Нийт амаржсан эхчүүдийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний 11 сарын байдлаар

Үзүүлэлт	2020 I-XI	2021 I-XI	2022 I-XI	$\frac{2022}{2021}$ %
Амаржсан эхийн тоо	36 176	33 455	31 721	-5.2
Гэрийн төрөлт	114	93	106	14.0
Хяналтгүй төрөлт	180	90	112	24.4
Амьд төрсөн хүүхэд	36 554	33 737	32 010	-5.1
Эхийн эндэгдэл	11	41	9	-78.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	431	372	396	6.5
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	11.8	11.0	12.4	-

2022 оны эхний 11 сард 32010 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 1727 (5.1%) хүүхдээр цөөн байна. Төрсөн нийт хүүхдийн 5596 (17.5%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлжээ.

ЗУРАГ 1. АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, дүүргээр




Төрсөн нийт хүүхдийн 16421(51.3%) нь хүү, 15589 (48.7%) нь охин байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 2 ихэр хүүхэд 445, 3 ихэр хүүхэд 9 байна.

Амьгүй төрөлтийн 188 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 12 тохиолдлоор буурсан байна. Амьгүй төрөлт Баянзүрх, Сүхбаатар, Багахангай, Налайх дүүрэгт хотын дунджаас өндөр байна.

¹ 2022 оны 1 дүгээр сараас Нийслэлийн Амаржих газрууд ЭМЯ-ны харьяа болсон.


ЗУРАГ 2. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН (1000 амьд төрөлтөд ногдох), эхний 11 сард



2022 оны эхний 11 сард бүртгэгдсэн нялхсын эндэгдлээс Сонгинохайрхан дүүрэгт 75 (18.9%) нь, Баянзүрх дүүрэгт 65 (16.4%) нь, Хан-Уул дүүрэгт 34 (8.6%) нь, Баянгол дүүрэгт 39 (9.8%) нь, Чингэлтэй дүүрэгт 25 (6.3%) нь, Сүхбаатар дүүрэгт 23 (5.8%) нь, Налайх дүүрэгт 8 (2.0%) нь, Багануур дүүрэгт 4 (1.0%) нь, бусад аймгийн харьяат 123 (31.1%) бүртгэгдсэн байна.

Нийслэлд 2022 оны эхний 11 сард 182966 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 62245 (25.4%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 447.8 продицимилээр тус тус буурсан байна.

ЗУРАГ 3. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварт өвчний төрлөөр нь авч үзвэл амьсгалын замын цочмог халдварт өвчин 174832 (95.6%), бэлгийн замаар дамжих халдварт өвчин 5595 (3.1%), гэдэсний халдварт өвчин 1085 (0.6%), зоонозын халдварт өвчин 21 (0.0%), бусад халдварт өвчин 1133 (0.7%) байна.

2022 оны эхний 11 сард **Коронавируст халдвар /COVID-19/-ын** 172165 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 94.1 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. НИЙСЛЭЛД ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Төрөл	Хэмжих нэгж	2020 I-XI	2021 I-XI	2022 I-XI	Өсөлт, бууралт 2022/2021	
					тоо/пункт	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	бодит тоо	16 218	245 211	182 966	-62 245	-25.4
	10000 хүнд	111.3	1 652.2	1 204.4	-447.8	
Үүнээс:						
Вируст хепатит	бодит тоо	170	63	112	49	77.8
	10000 хүнд	1.2	0.4	0.74	0.34	
Цусан суулга	бодит тоо	1 979	422	1 260	838	3.0**
	10000 хүнд	13.6	2.8	8.3	5.5	
Салхин цэцэг	бодит тоо	1 532	105	1 301	1 196	12.4**
	10000 хүнд	10.5	0.7	8.56	7.86	
Гахай хавдар	бодит тоо	41	3	8	5.0	2.7**
	10000 хүнд	0.3	0.02	0.05	0.03	
Сальмонеллөз	бодит тоо	160	19	155	136	8.2**
	10000 хүнд	1.1	0.1	1.0	0.9	
Улаан эсэргэнэ	бодит тоо	173	13	93	80	7.2**
	10000 хүнд	1.2	0.09	0.61	0.52	
Хоолны хордлого	бодит тоо	117	11	13	2	18.2
	10000 хүнд	0.8	0.1	0.1	0.0	
Ёлом	бодит тоо	88	11	30	19	2.7**
	10000 хүнд	0.6	0.07	0.2	0.13	
Бруцеллөз	бодит тоо	10	5	5	0	0.0
	10000 хүнд	0.1	0.03	0.03	0.0	
Гар хөл амны өвчин	бодит тоо	973	14	932	918	66.6**
	10000 хүнд	6.7	0.09	6.13	6.04	
Тэмбүү	бодит тоо	3 515	1 984	2 199	215	10.8
	10000 хүнд	24.1	13.4	14.5	1.1	
Гонококкт халдвар	бодит тоо	2 127	896	1 220	324	36.2
	10000 хүнд	14.6	6.0	8.0	2.0	
Трихомониаз	бодит тоо	1 753	828	1 080	252	30.4
	10000 хүнд	12.0	5.6	7.1	1.5	
Сүрьеэ	бодит тоо	1 949	1 319	1 273	-46.0	-3.5
	10000 хүнд	13.4	8.9	8.4	-0.5	
ДОХ	бодит тоо	22	12	12	0.0	0.0
	10000 хүнд	0.15	0.08	0.08	0.0	
Өөр бүлэгт ангилсан өвчний шалтгаан болох коронавирус – (Covid 19)	бодит тоо	520	238 693	172 165	-66 528	-27.9
	10000 хүнд	3.6	1 608.3	1 133.3	-475.0	

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



ЦАГ УУР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ (2022 оны 11 дүгээр сард)



Агаарын температур °C (Үнэмлэхүй их/бага)



-5.8°C

Хамгийн дулаан хэм



-30.6°C

Хамгийн хүйтэн хэм

Гал түймрийн тоо



2021 XI 1 408

2022 XI 1 639

16.4% ↑

Хүний үйл ажиллагаатай холбоотой осол



1

Үйлдвэрийн осол



53

Усны осол



182

Бусад

Байгаль орчны зөрчил



182

ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэлийн агаарын дундаж хэм 2022 оны 11 дүгээр сард дунджаар -10.6°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.6°C -аар, олон жилийн дундажтай харьцуулбал 0°C -аар хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 5.8°C , хамгийн хүйтэн хэм -30.6°C , хур тунадасны нийлбэр 5.8 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 13 метр секунд хүрсэн байна.

ХҮСНЭГТ 5. АГААРЫН БОХИРДОЛТ, $\text{мг}/\text{м}^3$, XI сард²

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO_2	0.050	493	0.374	281	0.085
Азотын давхар исэл	NO_2	0.050	397	0.123	190	0.051
Тоосжилт	PM_{10}	0.100	475	0.360	173	0.396
	$\text{PM}_{2.5}$	0.050	329	0.213	62	0.055
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	1344	11.702	5	1.884
Озон	O_3	0.100	865	0.062	-	0.016

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2022 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж $0.085 \text{ мг}/\text{м}^3$ (70.0%)-өөр, азотын давхар ислийн дундаж агууламж $0.051 \text{ мг}/\text{м}^3$ (2.0%)-ээр, PM_{10} тоосонцрын дундаж агууламж $0.396 \text{ мг}/\text{м}^3$ (3.9 дахин) тус тус өндөр байна.


ХҮСНЭГТ 6. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО, станц, 2022 оны XI сард

Станцын байршил	Азотын давхар исэл (NO_2)	Тоосонцор (PM_{10})	Озон (O_3)
Нийт	57	158	-
Мишээл экспо	3	4	-
Баруун 4 зам	28	17	-
Тахилт	25	17	-
13-р хороолол	17	11	-
Зуун айл	20	17	-
Цахилгаан станц	14	17	-
Ургах наран хороолол	9	15	-
Таван буудал	14	9	-
Богд хааны ордон музей	4	1	-
Нисэх	14	3	-
Толгойт	-	-	-
Зурагт	-	-	-
Амгалан	13	3	-
Баянхошуу	-	24	-


² 8 цагийн дундаж

Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар


ЗУРАГ 4. УЛААНБААТАР³ ХОТЫН АГААР ДАХЬ ХҮХЭРЛЭГ ХИЙН АГУУЛАМЖ, 8 станцын дундаж, мг/м³



ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН АГУУЛАМЖ, 11 станцын дундаж, мг/м³



ЗУРАГ 6. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ 10 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ АГУУЛАМЖ, 13 станцын дундаж, мг/м³



Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2022 оны 11 дүгээр сарын 09-10-ны өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хүчилтөрөгч 1.7 дахин, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 1.5 дахин, Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 4.1 дахин, Эрдэс фосфор 0.190 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

ХҮСНЭГТ 7. НИЙСЛЭЛИЙН ГАДАРГЫН УСНЫ НАЙРЛАГА, мг/м³, XI сард

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥ 6	11.70	1.7 дахин	4.41	1.5 дахин
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	БХХ ₅	≤ 3	2.8	Хэвийн	60.9	4.1 дахин
Нитритийн нэгдэл	NO ₂	≤ 0.02	0.002	Хэвийн	0.170	Хэвийн
Амоны азот	NH ₄	≤ 0.5	0.07	Хэвийн	0.588	Хэвийн
Эрдэс фосфор	P	≤ 0.1	0.003	Хэвийн	0.718	1.9 дахин

³ Багануур, Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдол хэмжих харуул цэг байхгүй.
Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

ХҮСНЭГТ 8. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХОНОГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, мг/м³, XI сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл Экспо төв	Баруун дөрвөн зам	Тахилт	13-р хороо- лол	Зуун айл	Цахил- гаан станц	Ургах наран хороо- лол	Хай- лааст	Таван буудал	Богд хааны ордон музей	Нисэх	Зурагт	Амга- лан	Баян- хошуу
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.034	0.036	0.105	0.032	0.054	0.027	0.040	0.087	0.095	0.020	0.095	0.191	0.045	0.226
	Хамгийн их	0.077	0.063	0.159	0.066	0.104	0.046	0.085	0.176	0.249	0.040	0.137	0.308	0.085	0.374
	XXX*-с давсан хувь	17	20	93	10	60	0	30	83	90	-	90	97	40	95
	Хэмжилтийн тоо	30	30	30	30	30	30	30	30	27	30	30	29	30	22
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.026	0.072	0.067	0.055	0.067	0.051	0.044	0.032	0.056	0.040	0.045	-	0.045	-
	Хамгийн их	0.072	0.093	0.091	0.075	0.123	0.078	0.070	0.045	0.072	0.055	0.067	-	0.072	-
	XXX*-с давсан хувь	13	93	83	457	69	47	30	-	74	14	48	-	48	-
	Хэмжилтийн тоо	23	30	30	30	29	30	30	30	19	28	29	-	30	-
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	1.062	1.914	3.249	1.437	1.921	0.993	0.224	3.455	-	0.623	1.455	3.597	1.294	-
	Хамгийн их	4.595	5.225	11.702	5.539	4.559	3.865	0.579	8.805	-	1.782	3.371	11.407	4.509	-
	XXX*-с давсан хувь	-	-	2	-	-	-	-	-	-	-	-	1	-	-
	Хэмжилтийн тоо	89	89	90	88	90	89	90	90	-	90	90	89	90	-
Тоос PM ₁₀	Дундаж	0.064	0.120	0.119	0.089	0.114	0.119	0.099	0.133	0.088	0.048	0.069	0.059	0.090	0.180
	Хамгийн их	0.144	0.293	0.233	0.206	0.210	0.293	0.181	0.226	0.154	0.113	0.110	0.098	0.176	0.396
	XXX*-с давсан хувь	13	59	57	38	59	57	50	70	30	3	10	-	9	80
	Хэмжилтийн тоо	30	29	30	29	29	30	30	30	30	30	30	29	30	30
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.045	-	0.029	-	-	-	0.109	0.068	0.016	0.053	0.047	0.049	0.087
	Хамгийн их	-	0.074	-	0.062	-	-	-	0.213	0.121	0.040	0.076	0.071	0.082	0.187
	XXX*-с давсан хувь	-	40	-	3	-	-	-	87	77	-	63	41	57	77
	Хэмжилтийн тоо	-	30	-	30	-	-	-	30	30	30	30	29	29	30
Озон O ₃ **	Дундаж	0.014	-	0.011	0.010	0.009	-	0.021	-	-	-	0.027	0.021	0.033	-
	Хамгийн их	0.038	-	0.038	0.033	0.023	-	0.043	-	-	-	0.062	0.048	0.060	-
	XXX*-с давсан хувь	-	-	0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	90	-	90	90	90	-	90	-	-	-	78	78	90	-

*Хүлцэх хэм хэмжээ

** CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Байгаль орчны зөрчил:

Нийслэлийн хэмжээнд 2022 оны эхний 11 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 182 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 9.9 хувийг ан амьтны зөрчил, 41.2 хувийг газрын зөрчил, 1.1 хувийг ойн зөрчил, 13.2 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 23.6 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 2.2 хувийг усны зөрчил, 3.8 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зөрчил, 3.8 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 1.1 хувийг бусад зөрчил тус тус эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 278.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

ХҮСНЭГТ 9. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗӨРЧИЛ, төрлөөр, 2022 оны эхний 11 сарын байдлаар

Илрүүлсэн зөрчил, Төрлөөр	2021 I-XI			2022 I-XI		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)
Бүгд	249	249	408.4	182	182	278.0
Ой	5	5	4.2	2	2	0.6
Ан, амьтан	47	47	52.7	18	18	13.8
Газрын	98	98	178.5	75	75	169.2
Ус	6	6	89.9	4	4	4.5
Ургамал, хөрсний бохирдол	-	-	-	-	-	-
Агаар, химийн хорт бодис	8	8	21.3	7	7	18.3
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	24	24	31.0	43	43	32.6
Геодези зураг зүй, кадастр	46	46	14.2	24	24	5.8
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	10	10	14.4	7	7	16.5
Бусад	5	5	2.06	2	2	0.35

Эх үүсвэр: НМХГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтэс

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2022 оны 11 дүгээр сард 236 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 22.3 хувиар өссөн байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд химийн бодисын 1 осол, усны 53 осол, бусад төрлийн 182 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 62 хүн амь насаа алдаж, 494 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 7.2 сая төгрөг зарцуулжээ.


ХҮСНЭГТ 10. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, дүүргээр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Дүүрэг	2017 I-XI	2018 I-XI	2019 I-XI	2020 I-XI	2021 I-XI	2022 I-XI	2021 2022 %
Нийслэлийн дүн	2 087	2 108	2 457	1 611	1 408	1 639	116.4
Багануур	28	24	37	26	23	24	104.3
Багахангай	3	5	5	4	8	4	-150
Баянгол	306	347	322	204	177	173	-102.2
Баянзүрх	481	485	587	368	330	401	121.5
Налайх	71	71	46	48	42	46	109.52
Сонгинохайрхан	465	447	623	403	336	429	127.6
Сүхбаатар	282	235	323	206	197	216	19.64
Хан-Уул	215	301	241	172	149	183	122.8
Чингэлтэй	236	193	273	180	146	163	111.6


Нийслэл хотод 2022 оны 11 дүгээр сард ахуйн 1639 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өссөн байна. Гал түймрийн улмаас 19 хүн амь насаа алдаж, 23 хүн түлэгдэж гэмтсэн байна. Худал дуудлагын тоо 10 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6 (40.0%)-аар буурсан байна.

Гал түймрийн аюулаас 2419 хүн, 371 байшин барилга, 13.5 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 526, санамсаргүй байдлаас 1085, шалтгаан тогтоогдоогүй 9, бусад шалтгаанаар 19 гал түймэр гарчээ.

ЗУРАГ 7. ГАЛ ТҮЙМЭР, байршлаар



ЗУРАГ 8. ГАЛ ТҮЙМЭР, шалтгаанаар



Гал түймэрт 1040 гэр, орон сууц, 35 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 120 машин техник, малын 6 хашаа, саравч, бусад төрлийн 438 объект өртжээ. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1227, төрийн өмчийн 321, хамтын болон гадаад улсын өмчийн 2, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 91 объект өртөж, нийт 6462.6 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2022 оны 11 дүгээр сард 191 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 561 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 132784 айл өрх, 5428 объектод үзлэг шалгалт хийж, 20815 галын зөрчил илрүүлж, 2 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 1771 заавал биелүүлэх албан шаардлага, 2574 мэдэгдэл хүргүүлж, 154.2 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



ГЭМТ ХЭРЭГ (2022 оны эхний 11 сард)

МОНГОЛ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүргээр)

2020 I-XI

14 920

2021 I-XI

22 741

52.4% ↑



↓ ↑ Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хувиар

Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

22 237



Гэмтсэн хүн

5 656



Нас барсан хүн


287

ГЭМТ ХЭРЭГ

2022 оны эхний 11 сард 22741 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7821 (52.4%) хэргээр, гэмт хэргийн илрүүлэлт 53.2 хувьтай байгаа нь 1.1 пунктээр тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 5656 хүн гэмтэж осолдон, 287 хүн нас барж, төр ард иргэдэд 256.4 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 148.5 тэрбум (57.9%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 40.6 хувийг залилан, 23.4 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 17.6 хувийг хулгайн, 2.6 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.7 хувийг дээрмийн, 1.7 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 1.2 хувийг хүчин, 0.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 0.4 хувийг хүн амь, 10.2 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 11. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, эхний 11 сарын байдлаар

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2022/2021	
	2020 I-XI	2021 I-XI	2022 I-XI	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	14 117	14 920	22 741	7 821	52.4
Хүний амь	95	104	97	-7	-6.7
Хүчин	191	205	275	70	34.1
Дээрэм	338	287	375	88	30.7
Хулгай	3 546	2 970	3 992	1 022	34.4
Залилан	3 406	4 874	9 237	4 363	89.5
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	4 315	4 088	5 326	1 238	30.3
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	428	398	580	182	45.7
Бусдыг амиа хорлоход хүргэх	90	78	138	60	76.9
Ашиглах	223	192	383	191	99.5
Танхайрах	9	6	9	3	50.0
Бусад	1 476	1 718	2 329	434	25.3

2022 оны эхний 11 сард 48472 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 597 (1.2%) хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 12. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2022/2021	
	2020 I-XI	2021 I-XI	2022 I-XI	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	14 117	14 920	22 741	7 821	52.4
Багануур	135	165	195	30	18.2
Багахангай	24	19	22	3	15.8
Баянгол	2 160	2 457	4 184	1 727	70.3
Баянзүрх	3 955	3 795	5 947	2 152	56.7
Налайх	321	255	313	58	22.7
Сонгинохайрхан	2 234	2 678	3 148	470	17.6
Сүхбаатар	2 078	2 070	3 572	1 502	72.6
Хан-Уул	1 494	1 795	2 730	935	52.1
Чингэлтэй	1 716	1 686	2 630	944	56.0

2022 оны эхний 11 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 20276 (89.2%) нь хөнгөн хэрэг, 2465 (10.87%) нь хүнд хэрэг байна.⁴

ХҮСНЭГТ 13. ГЭМТ ХЭРЭГ БҮРТГЭГДЭХ ҮЕД СЭЖИГТНЭЭР ТООЦВОЛ ЗОХИХ ЭТГЭЭД НЬ ТОГТООГДООГҮЙ ХЭРГИЙН ТОО, 2022 оны эхний 11 сарын байдлаар

Дүүрэг	Хэрэг бүртгэлтийн хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	
Нийслэлийн дүн	20 507	10 912	53.2
Багануур	142	83	58.5
Багахангай	6	4	66.7
Баянгол	4 015	2 231	55.6
Баянзүрх	5 436	2 871	52.8
Налайх	205	128	62.4
Сонгинохайрхан	2 792	1 440	51.6
Сүхбаатар	3 001	1 493	49.8
Хан-Уул	2 657	1 302	49.0
Чингэлтэй	2 253	1 360	60.4

⁴ Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж 2 ангилдаг болсон.

ЗУРАГ 10. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ, 2022 оны эхний 11 сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2022 оны эхний 11 сард 14205 болж, өмнөх оны мөн үеэс 4307 (43.5%) хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 2667 (18.8%) нь согтуугаар, 1611 (11.3%) нь бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг байна. Сэжигтэн, яллагдагчийн 948 (6.7%) нь хүүхэд, 3246 (22.9%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 14. БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Дүүрэг	Хулгайн гэмт хэргийн тоо, бүгд			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2020 I-XI	2021 I-XI	2022 I-XI	2020 I-XI	2021 I-XI	2022 I-XI
Нийслэлийн дүн	3 546	2 970	3 992	3 197	2 546	3 444
Багануур	24	21	38	22	0	30
Багахангай	6	4	5	5	3	5
Баянгол	318	425	714	250	331	580
Баянзүрх	1 014	749	909	870	623	774
Налайх	56	26	58	50	25	52
Сонгинохайрхан	770	635	711	677	576	631
Сүхбаатар	547	405	643	506	348	568
Хан-Уул	436	437	554	413	394	491
Чингэлтэй	435	268	360	404	226	313

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.


Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.




ТӨСӨВ (2022 оны эхний 11 сард)


ᠲᠥᠰᠤᠪ



Төсвийн орлого, зарлагын бүтэц



■ Татварын орлого
■ Татварын бус орлого



■ Урсгал зардал
■ Хөрөнгийн зардал


НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

Нийслэлийн төсвийн нийт орлого 2022 оны эхний 11 сард 1379.1 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 150.7 (993%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 1268.8 (92.0%) тэрбум төгрөгийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 110.3 (8.0%) тэрбум төгрөгийг татварын бус орлого тус тус эзэлж байна.

2022 оны эхний 11 сард нийслэлийн татварын орлого 1268.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 8.5 (0.7%) тэрбум төгрөгөөр төлөвлөгөө биелсэн, татварын бус орлого 110.3 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 159.3 (59.1%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

Орлогын албан татвар 29.1 (2.9%) тэрбум төгрөгөөр төлөвлөгөө биелсэн хэдийн ч хөрөнгийн албан татвар 13.1 (12.1%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр, хураамж 7.4 (4.6%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн.

ЗУРАГ 11. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг



ХҮСНЭГТ 15. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг, эхний 11 сарын байдлаар


Дүүрэг	Төсвийн орлого			Үүнээс:					
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Татварын орлого			Татварын бус орлого		
				Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
Нийслэлийн дүн	1 529 799.0	1 379 094.1	90.1	1 260 253.3	1 268 822.8	100.7	269 545.7	110 271.3	40.9
Багануур	11 123.4	12 343.6	111.0	10 184.4	10 467.5	102.8	939.0	1 876.1	199.8
Багахангай	951.8	1 052.6	110.6	680.5	842.0	123.7	271.3	210.6	77.6
Баянгол	152 432.7	112 435.5	73.8	149 648.3	110 110.8	73.6	2 784.4	2 324.7	83.5
Баянзүрх	206 520.9	132 991.9	64.4	205 100.8	128 062.5	62.4	1 420.1	4 929.4	3.5**
Налайх	9 715.2	9 755.6	100.4	8 891.6	8 800.5	99.0	823.6	955.1	116.0
Сонгинохайрхан	61 043.9	59 953.8	98.2	59 928.2	58 549.3	97.7	1 115.7	1 404.5	125.9
Сүхбаатар	256 082.4	243 259.9	95.0	254 268.5	241 247.2	94.9	1 813.9	2 012.7	111.0
Хан-Уул	214 187.5	201 186.1	93.9	210 495.8	195 425.6	92.8	3 691.7	5 760.5	156.0
Чингэлтэй	136 848.7	132 399.3	96.7	134 902.5	130 894.0	97.0	1 946.2	1 505.3	77.3
Хотын шууд ⁵	480 892.5	473 715.8	98.5	226 152.7	384 423.4	170.0	254 739.8	89 292.4	35.1

⁵ Хотын шууд татварт цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг төвлөрүүлдэг байсан бол 2022 оноос эхлэн дүүрэг бүрт орлогыг бүрдүүлдэг болсон.

ХҮСНЭГТ 16. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг, эхний 11 сарын байдлаар

Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
Нийт орлого	1 529 799.0	1 379 094.1	90.1
1. Татварын орлого	1 260 253.3	1 268 822.8	100.7
Орлогын албан татвар	991 068.7	1 020 177.3	102.9
Хувь хүний орлогын албан татвар	816 413.7	825 313.9	101.1
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	574 105.3	600 307.5	104.6
Үйл ажиллагааны орлогын	23 457.2	34 382.0	146.6
Хөрөнгийн орлого	108 314.7	72 188.7	66.6
Хөрөнгө борлуулсны орлогын	44 494.3	46 914.1	105.4
Шууд бус орлого	66 042.2	71 521.6	108.3
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(31 715.0)	(31 184.1)	98.3
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	206 370.0	226 047.5	109.5
Хөрөнгийн албан татвар	108 638.2	95 525.8	87.9
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	72 359.2	62 015.3	85.7
Бууны албан татвар	360.3	362.9	100.7
Малд ногдуулах албан татвар	281.0	203.6	72.5
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	35 637.7	32 944.0	92.4
Бусад татвар, төлбөр, хураамж	160 546.4	153 119.7	95.4
Бусад нийтлэг төлбөр, хураамж	62 149.2	56 791.3	91.4
Газрын төлбөр	83 953.8	83 912.5	100.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр	4 493.3	2 325.1	51.7
Бусад татвар	9 950.1	10 090.8	101.4
2. Татварын бус орлого	269 545.7	110 271.3	40.9
Нийтлэг татварын бус орлого	233 545.7	110 271.3	47.2
Хувьцааны ногдол ашиг	322.8	101.7	31.5
Төсөвт байгууллагын өөрийн орлого	16 097.0	11 508.2	71.5
Торгуулийн орлого	89 950.3	71 977.2	80.0
Түрээсийн орлого	1 895.3	1 625.6	85.8
Бусад орлого	125 280.3	25 058.6	20.0
Өмч хувьчлал	36 000.0	-	0.0

ЗУРАГ 12. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг




ХҮСНЭГТ 17. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг, эхний 11 сарын байдлаар

Дүүрэг	Зарлага			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийслэлийн дүн	2 409 402.5	1 486 295.6	923 106.9	61.7%
Багануур	14 373.1	11 518.8	2 854.3	80.1%
Багахангай	5 245.2	4 548.9	696.3	86.7%
Баянгол	160 066.4	107 231.1	52 835.3	67.0%
Баянзүрх	214 744.0	89 562.3	125 181.7	41.7%
Налайх	15 993.2	14 409.6	1 583.6	90.1%
Сонгинохайрхан	70 311.9	59 033.2	11 278.7	84.0%
Сүхбаатар	272 354.2	234 062.8	38 291.4	85.9%
Хан-Уул	231 410.4	169 927.8	61 482.6	73.4%
Чингэлтэй	157 581.6	121 854.8	35 726.8	77.3%
Хотын шууд	1 267 322.5	674 146.3	593 176.2	53.2%

2022 оны эхний 11 сард нийслэлийн төсвөөс нийслэл, дүүргийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 1486.3 (61.7%) тэрбум төгрөгийг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл нийслэл, дүүргийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө 923.1 (38.3%) тэрбум төгрөгийг зарцуулаагүй байна.

ЗУРАГ 13. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (2022 оны 11 дүгээр сард)

ХҮҮРГАЙН
ХАМГААГАХ
ТАВИА

Ерөнхий индекс

Хүнсний бараа, согтууруулах бус ундаа

Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис

Хувцас, бөс бараа, гутал

Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш

Гэр ахуйн тавилга, бараа

Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ

Тээвэр

Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ

Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ

Боловсролын үйлчилгээ

Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ

Даатгал, Санхүүгийн үйлчилгээ

Бусад бараа, үйлчилгээ

0.9

1.9

1.5

1.5

0.5

1.2

1.0

0

0.6

0.5

0

0

0

1.5


0 0.5 1.0 1.5 2.0

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар өслөө.

2022 оны 11 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс 2021 оны жилийн эцэстэй харьцуулахад 11.9 хувь, өмнөх сартай харьцуулахад 0.9 хувиар өссөн байна.

ЗУРАГ 14. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2022 оны 11 дүгээр сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 11.9 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 11.1 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 7.9 хувь, хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнэ 20.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 20.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 13.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 24.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 3.2 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 3.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 9.2 хувь, Боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 10.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 12.2 хувь, Даатгал, санхүүгийн үйлчилгээ бүлгийн үнэ 5.4 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 18.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 18. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2021-XI 2020-XI	2022-XI 2021-XI	2022-XI 2021-XII	2022-XI 2022-X
Ерөнхий индекс	110.0	114.5	111.9	100.9
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	119.1	115.3	111.1	101.9
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	107.0	108.5	107.9	101.5
Хувцас, бөс бараа, гутал	101.2	122.5	120.0	101.5
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	97.0	123.4	120.3	100.5
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.2	116.5	113.6	101.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	107.2	130.5	124.1	101.0
Тээвэр	120.4	103.8	103.2	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	103.6	103.1	103.1	100.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	101.7	109.9	109.2	100.5
Боловсролын үйлчилгээ	106.7	110.7	110.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	114.3	117.3	112.2	100.0
Даатгал, Санхүүгийн үйлчилгээ	-	105.4	105.4	100.0
Бусад бараа, үйлчилгээ	107.2	124.3	118.6	101.5

2022 оны 11 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 404 нэрийн бараа, үйлчилгээний 43 хувийн үнэ өсөж, 5 хувийн үнэ буурч, 53 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.


ХҮСНЭГТ 19. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН САРЫН ИНДЕКС, /**эерэг**, **сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	1.6	Энэ бүлгийн үнийн өсөлтөд талх, гурил, будааны үнэ 4.7 хувиар, сүү, загас, далайн бүтээгдэхүүний үнэ 0.5 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 5.0 хувиар, хүнсний ногооны үнэ 4.4 хувиар өссөн нь тус тус голлон нөлөөлөв.
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	1.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд шар айргийн үнэ 0.3 хувиар, архи, спиртийн үнэ 0.6 хувиар, тамхины үнэ 1.9 хувиар тус тус шууд нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	1.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд бүх төрлийн хувцас 2.0 хувиар, хувцас засвар, цэвэрлэгээ, түрээсийн үнэ 1.6 хувиар, бүх төрлийн гутал 0.9 хувиар, гутал засвар түрээсийн үнэ 2.2 хувиар тус тус голлон нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	0.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд орон сууцны бодит түрээс 6.6 хувиар, хатуу түлш 0.2 хувиар голлон нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	1.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд гэр ахуйн барааны үнэ 3.8 хувиар, гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы үнэ 1.7 хувиар тус тус нөлөөлөв.
Эм тариа, Эмнэлэгийн хэрэгсэл	1.0	Энэ бүлгийн үнийн өсөлтөд эм тарианы үнэ 1.8 хувиар шууд нөлөөлөв.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.6	Энэ бүлгийн үнийн өсөлтөд мэдээлэл холбооны хэрэгслийн үнэ 5.7 хувиар шууд нөлөөлсөн байна.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, бараа үйлчилгээ	0.5	Энэ бүлгийн өсөлтөд соёлын үйлчилгээ 0.1 хувиар, сонин, сэтгүүл, ном, бичгийн хэрэгсэл 1.4 хувиар тус тус нөлөөлөв.
